



**UnionPay виртуал кредит  
картын** олон улсын нисэх  
онгоцны буудлын лоунжид  
Dragonpass аппликэйшнээр  
үйлчлүүлэх гарын авлага




# Dragonpass аппликэйшныг татан гар утсанд суулгах




IOS үйлдлийн системтэй гар утсаар App Store Android үйлдлийн системтэй гар утсаар Google Play аппликэйшн руу хандаж татаж авна.




# Dragonpass аппликэйшнд бүртгүүлэх заавар




"Create Account"  
цэсийг сонгоно.




И-мэйл хаягаа  
бичиж "Continue"  
товч дээр дарна.



Шинээр 12  
оронтой нууц  
үгийг бичиж  
үргэлжлүүлнэ.




И-мэйл хаягаар  
ирсэн 6 оронтой  
баталгаажуулах  
кодыг оруулж  
үргэлжлүүлнэ.



Овог нэрээ  
бичээд "Continue"  
товч дээр дарна.

# Dragonpass аппликэйшнд бүртгүүлэх заавар


Анхааруулга: Гишүүнчлэл идэвхжээгүй тохиолдолд хоосон бүртгэл үүснэ.




Овог нэрээ зөв оруулсан эсэхийг баталгаажуулж үргэлжлүүлнэ.



Continue дарснаар бүртгэл амжилттай үүснэ.




Гишүүнчлэл идэвхжүүлэх цэсийг сонгох эсвэл "Skip for now" дарж алгасах боломжтой. /Гишүүнчлэлийг дараа идэвхжүүлэх боломжтой./




# Картаа ашиглах гишүүнчлэл идэвхжүүлэх заавар


Санамж: Карт идэвхтэй эсэхийг баталгаажуулахын тулд картын хүчинтэй хугацааг шалгах явцад 0.01 долларын суутгал хийх бөгөөд баталгаажуулалт дууссаны дараа мөнгийг таны дансанд автоматаар буцаан олгоно.




Гишүүнчлэлийг картын мэдээллээр идэвхжүүлэх бол "Yes" товч дээр дарна.




Картаар идэвхжүүлэхийг сонгоод үргэлжлүүлнэ.



Картын дэлгэрэнгүй мэдээллийг оруулна.




Мэдээллээ оруулсны дараа "Activate membership" товч дээр дарна.




Таны гишүүнчлэл амжилттай идэвхжлээ.


# И-мэйл хаягаар нэвтрэх заавар



"Sign in" товч дээр дарна.




Бүртгүүлсэн и-мэйл хаяг болон нууц үгээ оруулаад нэвтрэнэ.




Амжилттай нэвтрэгч орсноор Dragonpass нүүр хуудас руу шилжинэ.

# Лоунжид нэвтрэх заавар


Санамж: QR кодыг screenshot хийж ашиглах боломжгүй.




Бүртгүүлсэн и-мэйл хаяг болон нууц үгээ оруулан нэвтрэнэ.




Нүүр хуудасны "Lounge" цэсийг сонгоно.



Хайх хэсэгт нисэх онгоцны буудлын нэрийг бичиж оруулна.




Сонгосон лоунжийн байршил, цагийн хуваарь, дэлгэрэнгүй мэдээлэлтэй уншиж танилцан "Get access code" товч дээр дарна.




Таны сонгосон лоунжийн QR кодыг ажилтанд үзүүлснээр нэвтрэх эрх амжилттай баталгаажна.

# Харилцагчийн үйлчилгээ



Нүүр хуудсын "Account - Contact us" цэс рүү шилжинэ.




Гар утас болон и-мэйл хаягаар холбогдож лоунж-тэй холбоотой мэдээллийг тодруулах боломжтой.


Англи хэлээр  
+44 808 196 6002 (24 цаг )  
+86 400-871-9196 (Даваа –  
Баасан, Бээжингийн цагаар  
9:00-17:00)  
support@dragonpass.com

Хятад хэлээр  
+86 513 8719 9488 (24 цаг)  
DPservice@dragonpass.com.cn


# Нэмэлт үйлчилгээ – Зоогийн газрын хөнгөлөлт




Нүүр хуудасны "Dining" товч дээр дарна.




Хайх хэсэгт онгоцны буудлын мэдээллийг бичиж, үйлчлүүлэх боломжтой жагсаалтаас сонголт хийнэ.



Хоолны газрын дэлгэрэнгүй мэдээлэлтэй уншиж танилцан "Redeem offer" товч дээр дарна.



Хөнгөлөлттэй газраар үйлчлүүлэхэд гишүүнчлэлийн эрхээс хасагдаж тооцохгүй.



# Түгээмэл асуулт - 1

**Асуулт:** Миний кредит картыг систем таниагүй учраас лоунжийн нэвтрэх эрх үүсээгүй бол яах вэ?

**Хариулт:** Систем нь DragonPass сүлжээний бүх хэрэглэгчдийг танихаар тохируулагдсан байдаг. Хэрэв таны карт танигдаагүйгээс болж лоунжид нэвтрэх эрх үүсээгүй бол DragonPass аппликэйшн руу нэвтэрч, гишүүнчлэлийн статусаа шалгана уу.

**Асуулт:** Өөр хүн миний кредит картыг ашиглан лоунжид үйлчлүүлэх боломжтой юу?

**Хариулт:** Үгүй, зөвхөн карт эзэмшигч өөрийн картаа ашиглан лоунжид нэвтрэх боломжтой байна. Лоунийн ажилтан харилцагчийн нэрийг нислэгийн тасалбар болон паспорттой тулгана.

**Асуулт:** Би кредит картаа нөхөн авалт хийсэн/дахин захиалсан ч лоунжид орж болох уу?

**Хариулт:** Тийм, Dragon pass-ийн гишүүнчлэлийн хугацаа хүчинтэй бол орж болно. Dragon Pass аппликэйшн руу нэвтэрч орсноор гишүүнчлэл баталгаатай байгаа эсэхийг шалгах боломжтой.

**Асуулт:** Надаас үйлчлүүлэх ёсгүй байсан лоунжийн төлбөрийг авсан. Хаана хандан шалгуулах вэ?

**Хариулт:** Үйлчилгээний төлбөртэй холбоотой асуудлаар DragonPass харилцагчийн үйлчилгээний утас руу холбогдох, эсвэл шууд мэйл илгээж шалгуулах боломжтой.

# Түгээмэл асуулт - 2

**Асуулт:** Лоунжийн үйлчилгээнд сэтгэл ханамжгүй бол хэрхэн гомдол гаргах вэ?

**Хариулт:** DragonPass харилцагчийн үйлчилгээний утас болон мэйлээр хугацаа, гомдлын дэлгэрэнгүй мэдээллийг илгээх боломжтой.

**Асуулт:** Лоунжийн ажилтан хамт явж буй зочноос төлбөр авах талаар хэлээгүй ч надаар төлүүлсэн. Энэ тохиолдолд яах вэ?

**Хариулт:** DragonPass-ийн журмын дагуу лоунжийн үйлчилгээ үзүүлэгч нь төлбөр төлсөнтэй холбоотой ямар нэгэн мэдээлэлд хандах эрхгүй байдаг. Иймд лоунжид нэвтрэхдээ орох зочдын тоог шалгаж байна уу. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Dragon Pass харилцагчийн үйлчилгээний ажилтантай холбогдох боломжтой.

**Асуулт:** Лоунжид ямар хугацаанд үйлчлүүлэх боломжтой вэ?

**Хариулт:** Лоунж бүр хэрэглэгч нарт үйлчлүүлэх хугацааны хязгаарлалт тавьсан байдаг. Энэхүү хугацаа дууссаны дараа дахин үйлчлүүлэх боломжтой эсэх нь лоунжийн дүрэм журмаас хамаарна. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл аппликэйшнаас тухайн лоунж руу орон харах боломжтой.

**Асуулт:** Лоунжид хүүхдээ үнэгүй авч орж болох уу?

**Хариулт:** Лоунжид зочинтой хамт орох боломжтой ч лоунж бүрийн бодлого журмаас хамаарна. Аппликэйшн руу орон лоунжийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцана уу.

**Асуулт:** Лоунжид үйлчлүүлэхэд дижитал карт олгох уу?

**Хариулт:** Тийм, DragonPass-н хэрэглэгчид дижитал карт болон лоунжийн эрхээ баталгаажуулсан кредит картаа ашиглах боломжтой.

**Асуулт:** Хамт яваа зочныг яагаад лоунжид оруулахаас татгалзсан бэ?

**Хариулт:** DragonPass-н хэрэглэгчтэй хамт хэдэн зочин хүлээн авахыг хүлээн авах лоунжийн бодлого журмаар шийднэ. DragonPass аппликэйшнаараа авч орох боломжтой зочдын тоог шалгана уу.

## Түгээмэл асуулт - 3

**Асуулт:** Хамт яваа хүн бид 2 хоёулаа лоунжид үйлчлүүлэх DragonPass эрхтэй. Лоунжаар үйлчлүүлэхдээ хоёулаа дижитал карт юм уу кредит картаа үзүүлэх хэрэгтэй юу?

**Хариулт:** Тийм, ямар нэгэн шаардлагагүй төлбөр давхар төлөхгүйн тулд лоунж руу нэвтрэхдээ хоёулаа үзүүлэх шаардлагатай.

**Асуулт:** Лоунж руу зочинтой хамт орох тухай дүрэм журам нь юу байдаг вэ?

**Хариулт:** Харилцагч зочдыг хамт дагуулан лоунжоор үйлчлүүлэх боломжтой. Ихэнх танхимд хэдэн ч зочин оруулах боломжтой ба карт эзэмшигч заавал байх ёстой. Хамт орж буй зочин бүрийн тоогоор таны эрхээс хасагдах болно.

**Асуулт:** Хэрвээ миний нислэг хойшлогдох эсвэл цуцлагдвал лоунжийн ажилтнаас тусламж авах боломжтой юу?

**Хариулт:** Үгүй, агаарын тээврийн компанитай шууд холбогдоорой.

**Асуулт:** Лоунжийн байршлыг хаанаас мэдэх боломжтой вэ?

**Хариулт:** DragonPass аппликэйшн ашиглан дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой.

**Асуулт:** DragonPass нь тусгай гарцын үйлчилгээг үзүүлэх үү?

**Хариулт:** Үгүй, DragonPass нь зөвхөн өөрийн сүлжээний лоунжуудад нэвтрэх боломжийг олгодог. DragonPass аппликэйшн ашиглан дэлгэрэнгүй мэдээллийг аваарай.

## Түгээмэл асуулт - 4

**Асуулт: DragonPass аппликэйшн хэрхэн ашиглах вэ?**

**Хариулт:** DragonPass аппликэйшнийг татаж аван бүртгэл үүсгэх ба төлбөрийн картынхаа мэдээллийг оруулах шаардлагатай бөгөөд энэ нь тэдний хөтөлбөрт хамрагдах эрхийг баталгаажуулна. Баталгаажуулалтыг карт гаргагчийн өгсөн үйлчлүүлэгчийн төлбөрийн картаар баталгаажуулдаг.

**Асуулт: Аппликэйшний шинэ хувилбарт ямар өөрчлөлтүүд орсон бэ ?**

**Хариулт:** Аппликэйшнд шинэ цэсүүд нэмэгдсэн ба ашиглахад илүү хялбар болсон.

**Асуулт: Шинэ DragonPass аппликэйшний ашиглах шаардлага юу вэ?**

**Хариулт:** DragonPass аппликэйшн нь iOS болон Android төхөөрөмжүүд дээр боломжтой байдаг. Үйлдлийн системийн хамгийн бага шаардлага нь iOS 11 болон Android 6.0 юм.

**Асуулт: Картаа шинээр авсан тохиолдолд яах вэ?**

**Хариулт:** DragonPass аппликэйшн дээр гишүүнчлэлээ идэвхжүүлэхийг зөвлөж байна. Идэвхжүүлэх явцад танаас төлбөрийн картаа баталгаажуулахыг хүсэх болно. Үүний дараа та мэдээллээ дахин баталгаажуулах шаардлагагүйгээр лоунж руу нэвтрэх боломжтой.

## Түгээмэл асуулт - 5

**Асуулт: Нэвтрэх эрх олгогдоогүй байвал юу хийх хэрэгтэй вэ?**

**Хариулт:** Хэрэв DragonPass бүртгэлгүй бол аппликэйшн руу орж бүртгүүлэх ба картаараа баталгаажуулалт хийсний дараа лоунжид нэвтрэх боломжтой болно.

Бүртгэлтэй харилцагчийн хувьд DragonPass аппликэйшн руу орж гишүүнчлэлээ идэвхжүүлнэ. Картаараа баталгаажуулалт хийсний дараа лоунжид нэвтрэх боломжтой болно.

**Асуулт: Лоунжид нэвтэрч болохгүй бол хэнтэй холбогдох вэ?**

**Хариулт:** DragonPass бүртгэлээ үүсгэж гишүүнчлэлээ идэвхжүүлэхийг санал болгож байна. Хэрэв энэ тохиолдолд ч нэвтэрч болохгүй бол Dragon Pass харилцагчийн үйлчилгээний ажилтантай холбогдоорой.